

# ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Ж.Тунгалаг

*Ахлах мэргэжилтэн*

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл

[www.acsmon.mn](http://www.acsmon.mn) ◆ [tungalag@acsmon.mn](mailto:tungalag@acsmon.mn)



## ҮНЭЛГЭЭ

**Шаардлагатай мэдээллүүдийг цуглуулж, задлан шинжилж, үр дүнг тайлагнах үйл ажиллагаа юм.**

# ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Өөрийн сул ба давуу талыг тодорхойлж,  
өөрсдийнхөө үйл ажиллагаанд бодитой дүн  
шинжилгээ хийж, оюутанд /нийгэмд/ үзүүлж  
байгаа үйлчилгээгээ илүү үр ашигтай,  
чанартай болгох хэрэглүүр юм.





# Өөрийн үнэлгээнд гарч байгаа түгээмэл дутагдлууд

- Урьд өмнө хийсэн үйл ажиллагаандаа хандсан
- Үйл ажиллагаагаа нуршин дүрсэлсэн
- Одоогийн байгаа байдлыг хамгаалан хайцаалсан
- Сул талыг илрүүлэхээсээ хэт магтан дөвийлгөсөн
- Үнэлгээг хэтийн эрэлт хэрэгцээндээ баримжаалж хийгээгүй
- Хамт олны оролцоо муу, нээлттэй, ил тод биш
- Чанарыг тасралтгүй сайжруулах арга замыг тодорхойлоогүй

# ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Энэ нь магадлан итгэмжлэх үйл ажиллагааны хамгийн чухал элемент бөгөөд тухайн сургуулийн /салбар, нэгжийн/ эрхэм зорилго, зорилтуудын хэрэгжилт, үр дүн нь магадлан итгэмжлэлийн шалгуур, шаарплагуудыг хангаж байгааг нотлох баримт юм.





## Тайлан бичихэд баримтлах зарчмууд

- Үнэн, зөв, бодит мэдээлэлд тулгуурласан байна
- Хэл найруулга сайтай, хүснэгт график нь ойлгомжтой байна
- Тоочиж дурьдахдаа биш үйл ажиллагаандаа шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт хийсэн байна



# ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

## 1. ОРШИЛ

## 2. ТАЙЛАНГИЙН ҮНДСЭН ХЭСЭГ

- ◆ Эрхэм зорилго, зорилтууд
- ◆ Төлөвлөлт, төсөвлөлт
- ◆ Засаглал, эрх зүйн зохицуулалт
- ◆ Хүний нөөцийн хөгжил
- ◆ Материаллаг болон технологийн нөхцөл
- ◆ Хөтөлбөрийн шинэчлэл
- ◆ Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ
- ◆ Судалгаа, инновац
- ◆ Нийгэмд чиглэсэн үйлчилгээ
- ◆ Үндэсний болон олон улсын хэмжээнд эзлэх байр суурь

## 3. ДҮГНЭЛТИЙН ХЭСЭГ

## 4. Хавсралтууд





## ОРШИЛ ХЭСЭГ

- Оршил нь товч, тодорхой, тайлангийн хаана юуны тухай бичсэнийг харж болохуйц байна
  - Тайлангийн зорилго
  - Тайлангийн бүтэц, бүлэг зүйлүүд
- Өөрийн үнэлгээний ямар баг бүрдүүлж, ямар үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэнийг харуулах
- Өмнө нь үнэлгээ хийж, дүгнэлт өгч байсан бол тэдгээр дүгнэлтүүдийг хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авсаныг харуулах



# ҮНДСЭН ХЭСЭГ

- Шалгуур, шаардлага тус бүрт хамаарах процессын чанарыг тоо баримт, нотлох баримтад тулгуурлан судалгаа шинжилгээний үндэслэлтэй нарийн нягт тодорхойлон, үр дүнгийн ололттой, дэвшилттэй тал, түүний үр нөлөөг тодорхойлно. Мөн дутагдалтай тал, анхаарах асуудлуудыг тодотгоно.
  - тухай хэсгүүдийн хооронд зохистой тэнцвэрт байдлыг хадгалах
- Шалгуур, шаардлага бүрийн хүрээнд цаашид хийх ажил, юуг өөрчлөх, юуг дахин судлах шаардлагатай, ямар нэмэлт мэдээлэл бүрдүүлэх зэргийг тусгасан зөвлөмжийн хэсгийг оруулбал зохимжтой.





## **ДҮГНЭЛТИЙН ХЭСЭГ**

- **Өөрийн үнэлгээ хийсэн аргачлал**
- **Өөрийн үнэлгээ хийх явцад ажиглагдсан гол чухал асуудлууд**
- **Ерөнхий дүгнэлт**

# Чанарын үнэлгээний зарим аргачлал

- Процессын бүдүүвч
- График
- Парето анализ
- Загасны ясан /Ишикава/ диаграм
- Түгэлтийн диаграм
- Шалгах хуудас
- Хянах хүснэгт
- Оюуны довтолгоо
- Бенчмаркинг /харьцуулалт
- SWOT анализ

# SWOT шинжилгээ

- **SWOT шинжилгээ нь байгууллагын гадаад ба дотоод орчны хүчин зүйлүүд дээр үндэслэн түүнийг нилээд сайн өрсөлдөх байр сууринд хүрэхэд нөлөөлөх нөхцөл байдлыг тодорхойлох үндсэн арга юм.**

# SWOT / TOWS матриц

<b>Дотоод орчин</b>  <b>Гадаад орчин</b>	<b>Давуу тал (S)</b> (5-10 дотоод давуу талаа эрэмбэлсэн жагсаалт)	<b>Сул тал (W)</b> (5-10 дотоод сул талаа эрэмбэлсэн жагсаалт)
<b>Боломж (O)</b> (5-10 гадаад боломжийг эрэмбэлсэн жагсаалт)		
<b>Эрсдэл (T)</b> (5-10 гадаад аюулыг эрэмбэлсэн жагсаалт)		

# Давуу тал */Strengths/*

Үйл ажиллагаа явуулах чадвар болон биет ба биет бус нөөц юм.

- санхүүгийн болон хүний нөөц
- нэр хүнд, найдвартай байдал
- бусдад танигдсан дүр төрх /нэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ/
- онцгой чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ
- зах зээлд эзлэх тэргүүлэх байр суурь
- байнгын үйлчлүүлэгч, найдвартай хамтрагчид
- зохиогчийн эрхтэй бүтээл, патент
- мэдээллийн систем
- биенес явуулах бусад үнэ цэнэтэй нөөц



# Сул тал */Weaknesses/*

Тухайн байгууллагын үр ашигтай ажиллахад саад болдог дутагдалтай байдал, зах зээлд өрсөлдөх чадварыг бууруулдаг хүчин зүйлүүд юм.

- санхүүгийн эх үүсвэр болон нөөцийн дутагдал
- удирдлагын ур чадвар сул
- мэдлэг туршлага, чадварын хомсдол
- бүтээгдэхүүн болон үйлчилгээний нэр төрөл цөөн
- технологийн хоцрогдол
- өндөр зардал, үр ашиггүй санхүүжилт
- зах зээлийн багтаамж бага
- зах зээлийн судалгаагүй
- бодлого тодорхой бус гэх мэт

# **Боломж /Opportunities/**

Байгууллагын орчны хамгийн таатай нөхцөл, стратегийн зорилтуудаа хэрэгжүүлэхэд дэмжлэг болох хүчин зүйлүүд юм.

- **Зах зээлийн орон зайд танигдах байр суурь**
- **урт хугацаанд өрсөлдөх чадвар**
- **өсөн дэвжих хэтийн төлөв**
- **бодлого, зохицуулалтын өөрчлөлт**
- **техник, технологийн дэвшил, шинэ технологи**
- **шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ**
- **үйлчлүүлэгчидтэйгээ сайн харилцаатай байх**
- **үйлчлүүлэгчдийн хэрэгцээ сонирхол нэмэгдэх**
- **зах зээлийн өсөлт**

# **Бэрхшээл /Threats/**

Үр ашиггүй бизнесийн хөгжил болон хандлагаас үүсдэг хамгийн таагүй нөхцөл бөгөөд ашиг орлогыг бууруулж, одоогийн болон хүрэхийг зорьж буй зорилтын гол саад тотгор болдог хүчин зүйлүүд юм.

- **өрсөлдөөний дарамт өсөх, байр сууриа алдах**
- **өрсөлдөгч байгууллага илүү чанартай бүтээгдэхүүн гаргах**
- **мөнгөний ханшны таагүй өөрчлөлт, зээлийн хүүний өсөлт**
- **эрх зүйн орчны тогтворгүй байдал**
- **Зах зээл багасах**
- **Үйлчлүүлэгчийн хэрэгцээ, сонирхол өөрчлөгдөх**
- **Технологийн үсрэнгүй хөгжил танай бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэгцээнээс гаргах**

# SWOT / TOWS матриц

<p style="text-align: center;">Дотоод орчин</p> <p style="text-align: center;">Гадаад орчин</p>	<p><b>Давуу тал (S)</b> (5-10 дотоод давуу талаа эрэмбэлсэн жагсаалт)</p>	<p><b>Сул тал (W)</b> (5-10 дотоод сул талаа эрэмбэлсэн жагсаалт)</p>
<p><b>Боломж (O)</b> (5-10 гадаад боломжийг эрэмбэлсэн жагсаалт)</p>	<p><b>S-O стратеги</b> Боломжийг давуу тал болгон ашиглах стратегийг томъёолох</p>	<p><b>W-O стратеги</b> Давуу талаа ашиглан аюулаас зайлсхийх стратегийг томъёолох</p>
<p><b>Эрсдэл (T)</b> (5-10 гадаад аюулыг эрэмбэлсэн жагсаалт)</p>	<p><b>S-T стратеги</b> Боломжинд тулгуурлан сул талаа үгүй хийх стратегийг томъёолох</p>	<p><b>W-T стратеги</b> Сул талаа багасгаж, аюулаас зайлсхийх стратегийг томъёолох</p>

# Үйл ажиллагааны стратеги боловсруулалт

	<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<b>Боломж</b>	<b>S-O стратеги</b>	<b>S-T стратеги</b>
<b>Эрсдэл</b>	<b>W-O стратеги</b>	<b>W-T стратеги</b>

# SWOT шинжилгээний дараа ...





[www.accmon.mn](http://www.accmon.mn)

tungalag@accmon.mn